



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/27

Бор-Өндөр сум

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2026 оны Бор-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан “Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн ханын хийн болон соруулгын нэгдсэн систем худалдан авах” бараа нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

А.Өлзийсүрэн

Бэлчээр тэжээл, газар тариалан
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Э.Оюунболор

Хөндлөнгийн гишүүн

Э.Минжинсор

Хөндлөнгийн гишүүн

Ц.Отгонжаргал

Иргэний төлөөлөл

2. Бор-Өндөр суманд “Нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн ханын хийн болон соруулгын нэгдсэн систем худалдан авах” бараа сонгон шалгаруулах ажлыг зохих хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ